



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар A/166

Улаанбаатар хот

**Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн
бэлтгэл шатны сургалт зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын 4.1, 4.2, 4.6 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/1085 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2024 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дүйцүүлэх алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлага олгох “Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Багануур дахь Хилийн цэргийн 0252 дугаар ангийн байрлалд сургалтанд бүрэн хамруулахыг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Сургалтад хамрагдах цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1.537,470 (Нэг сая таван зуун гучин долоон мянга дөрвөн зуун дал) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 22 ны өдрийн 416 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ СУРГАЛТАД
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоол	14 хоног	8 хүн	8x10.500	1.176.000
2	Гэрчилгээ	ш	8	25.000	200,000
3	Бензин А-92 170x15л 340 км	Литр	67	2410	161,470
НИИТ					1.537,470